


	<h2 style="font-size: 48px; margin: 0;">46</h2> <p style="font-size: 12px; margin: 0;">НИЙТ 100 ОНООНООС</p> <hr/> <h3 style="margin: 0;">ИЛ ТОД БАЙДАЛ</h3> <p style="font-size: 10px; margin: 0;">төсвийн нээлттэй байдлын индекс</p> <p style="font-size: 10px; margin: 0;">Монгол Улс төсвийн талаараа олон нийтэд өгдөг мэдээлэл нь хязгаарлагдмал.</p>	<h2 style="font-size: 48px; margin: 0;">7</h2> <p style="font-size: 12px; margin: 0;">НИЙТ 100 ОНООНООС</p> <hr/> <h3 style="margin: 0;">ИРГЭДИЙН ОРОЛЦОО</h3> <p style="font-size: 10px; margin: 0;">Монгол Улсад төсвийн үйл явцад иргэд оролцох боломж бага.</p>	<h2 style="font-size: 48px; margin: 0;">76</h2> <p style="font-size: 12px; margin: 0;">НИЙТ 100 ОНООНООС</p> <hr/> <h3 style="margin: 0;">ТӨСВИЙН ХЯНАЛТ</h3> <p style="font-size: 10px; margin: 0;">ХУУЛЬ ТОГТООХ БОЛОН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА</p> <p style="font-size: 10px; margin: 0;">Монгол Улсын хууль тогтоох болон аудитын дээд байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт хангалттай.</p>
--	---	--	---

📖 ИЛ ТОД БАЙДАЛ (ТӨСВИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ИНДЕКС)


Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь олон талт хамтын ажиллагааны байгууллагуудын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгуураар боловсруулсан 109 үзүүлэлтээр төсвийн ил тод байдлыг тодорхойлдог. Эдгээр үзүүлэлтээр тухайн улсын засгийн газар төсвийн гол найман баримт бичгийг онлайн аар цаг тухайд нь олон нийтэд ил болгосон эсэх, мөн ил болгосон мэдээлэл нь иж бүрэн, ойлгомжтой, ашиглахад хялбар эсэхийг үнэлдэг.

Нийт авбал зохих 100 онооноос авсан оноогоор нь улсуудыг эрэмбэлдэг. Төсвийн нээлттэй байдлын индекс нь төсвийн ил тод байдлыг харьцуулан үнэлдэг дэлхийн цор ганц хараат бус үнэлгээ юм.

Монгол Улсын төсвийн нээлттэй байдлын оноо (оноор)



Монгол Улсын төсвийн ил тод байдлыг бусад улстай харьцуулсан байдал




Төсвийн баримт бичгийг олон нийтэд ил тод болгосон байдал, 2006 - 2017 он

Баримт бичиг	2006	2008	2010	2012	2015	2017
Төсвийн хүрээний мэдэгдэл	🟢	🟢	🟢	🟢	🟢	🟡
Гүйцэтгэх засаглалын төсвийн санал	🟡	🟢	🟢	🟢	🟢	🟢
Батлагдсан төсөв	🟢	🟢	🟢	🟢	🟢	🟢
Иргэдэд зориулсан төсөв	🔴	🔴	🔴	🔴	🟢	🔴
Жилийн явцын тайлангууд	🟢	🟢	🟢	🟢	🟢	🟢
Хагас жилийн тойм	🟡	🟡	🟡	🟡	🔴	🟡
Жилийн эцсийн тайлан	🟢	🟡	🟢	🟢	🟢	🟡
Аудитын тайлан	🟢	🟡	🟢	🟢	🟢	🟢

● Олон нийтэд нээлттэй
 ● Боловсруулаагүй
● Хожуу нийтэлсэн/ Онлайнаар нийтлээгүй/ Дотоод хэрэгцээнд зориулж боловсруулсан

Монгол Улсын төсвийн баримт бичгүүд дэх мэдээллийн иж бүрэн, ойлгомжтой, ашиглахад хялбар байдал



Монгол Улс нийт авбал зохих 100 онооноос 46 авсан нь дэлхийн дундаж болох 42 оноотой ойролцоо байна.

Монгол Улс 2017 оны төсвийн нээлттэй байдлын индекст 46 оноо авсан нь 2015 оны үзүүлэлттэй ойролцоо байна.

Монгол Улс 2015 оноос хойш дараах байдлаар төсвийн мэдээллийн хүртээмжийг сайжруулжээ. Үүнд:

- Гүйцэтгэх засаглалын төсвийн санал дахь мэдээллийг нэмэгдүүлсэн.
- Аудитын тайлан дахь мэдээллийг нэмэгдүүлсэн.

Хэдий тийм ч Монгол Улс дараах байдлаар төсвийн мэдээллийн нээлттэй байдлыг бууруулсан. Үүнд:

- Жилийн эцсийн тайланг зөвхөн дотоод хэрэгцээнд зориулж боловсруулсан.
- Төсвийн хүрээний мэдэгдлийг цаг тухайд нь онлайнаар нийтлээгүй.
- Иргэдэд зориулсан төсвийн мэдээлэл гаргаагүй.

Монгол Улс:

- Хагас жилийн тойм боловсруулсан ч иргэдэд нээлттэй болгоогүй байна.

Төсвийн үндсэн баримт бичгүүд

Төсвийн хүрээний мэдэгдэл: Эдийн засгийн төсөөлөл, төсвийн орлого, зарлага, өр зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг тусгасан Гүйцэтгэх засаглалын төсвийн санал гаргахаас өмнө өргөн мэдүүлдэг төсөв санхүүгийн бодлогын баримт бичиг юм.

Гүйцэтгэх засаглалын төсвийн санал: Хууль тогтоох байгууллагаар батлуулахаар өргөн барьдаг орлогын эх үүсвэр, хуваарилалт, бодлогын өөрчлөлт болон улс орны санхүүгийн нөхцөл байдлыг тодорхойлсон бусад чухал мэдээллийг агуулсан баримт бичиг юм.

Батлагдсан төсөв: Хууль тогтоох байгууллагаас баталсан төсөв.

Иргэдэд зориулсан төсөв: Иргэдэд ойлгомжтой байдлаар боловсруулсан Гүйцэтгэх засаглалын төсвийн санал эсвэл Батлагдсан төсвийн мэдээлэл.

Жилийн явцын тайлангууд: Сар эсвэл улирлын давтамжтай гаргадаг бодит орлого, зарлага, улсын өрийн хэмжээ зэрэг мэдээлэл агуулсан баримт бичиг.

Хагас жилийн тойм: Хагас жилийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй танилцуулга, эдийн засгийн үзүүлэлтүүд, төсвийн гүйцэтгэлийн шинэчилсэн төсөөлөл зэргийг багтаасан мэдээлэл.

Жилийн эцсийн тайлан: Санхүүгийн жилийн эцэст Засгийн газрын санхүүгийн байдлыг тайлагнаж төсвийн бодлогод нийцэж ажилласан эсэхийг үнэлэх баримт бичиг.

Аудитын тайлан: Аудитын дээд байгууллагаас гаргадаг засгийн газрын жилийн эцсийн тайланг дүгнэсэн баримт бичиг.




ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Засаглалыг сайжруулахад дан ганц төсвийн ил тод байдал хангалтгүй. Төсвийн ил тод байдлын үр ашгийг хүртэхийн тулд төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо нэн чухал юм.

Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь Засгийн газар иргэддээ төсвийн үйл явцад оролцох боломж хэр их олгож байгаагаар иргэдийн оролцоог үнэлдэг. Гүйцэтгэх засаглал, хууль тогтоох болон аудитын дээд байгууллагын зүгээс төсвийн мөчлөгийн бүх шатны үйл явцад иргэд оролцох боломжийг бий болгож байх ёстой.


Дэлхий дахины санхүүгийн ил тод байдлын санаачилгаас гаргасан иргэдийн оролцоог үнэлэх шинэ зарчмуудтай уялдан иргэдийн оролцоог үнэлэх судалгааны асуулгууд өөрчлөгдсөн. Эдгээр зарчим нь улсын төсвийн үйл явц дахь иргэдийн оролцооны үндсэн хэм хэмжээг тодорхойлох болсон. Тиймээс 2017 оны Төсвийн нээлттэй байдлын судалгааны иргэдийн оролцооны үнэлгээг өмнөх жилүүдийнхтэй шууд харьцуулах боломжгүй юм.

Монгол Улсын төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоог бүс нутгийн бусад улстай харьцуулбал:



Монгол Улс 100 онооноос 7 оноо авсан нь төсвийн үйл явцад иргэд оролцох боломж **бага** байгааг харуулж байна. Энэ нь дэлхийн дундаж болох 12 онооноос доогуур үзүүлэлт юм.

Монгол Улсад төсвийн үйл явцад иргэд оролцох боломжийг институциуд олгож байгаа байдлыг харьцуулбал:






ТӨСВИЙН ХЯНАЛТ

Төсвийн нээлттэй байдлын судалгаагаар хууль тогтоох байгууллага, аудитын дээд байгууллага болон хараат бус санхүүгийн институтын зүгээс төсвийн үйл явцад оролцож буй байдал мөн төсөвт үр дүнтэй хяналт тавьж буй эсэхийг үнэлдэг. Эдгээр байгууллага үндсэн хууль эсвэл бусад хуульд заасан үүргийнхээ дагуу улсын төсвийг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавихад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Нийтийн баялгийг ёс зүйтэй, хариуцлагатай ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих үүргээ албан ёсны хяналтын байгууллагууд хэрхэн биелүүлж байгааг нарийвчлан үнэлэх зорилгоор судалгааны асуулгууд өөрчлөгдсөн. Тиймээс 2017 оны Төсвийн нээлттэй байдлын судалгааны төсвийн хяналтын үнэлгээг өмнөх жилүүдийнхтэй шууд харьцуулах боломжгүй юм.

Хууль тогтоох байгууллагаас төсөвт тавьж буй хяналт




Хууль тогтоох байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт **хангалттай** байна. Дээрх оноо нь хууль тогтоох байгууллагын зүгээс тавих хяналт төсвийн мөчлөгийн төлөвлөлтийн үе шатанд хангалттай, харин хэрэгжилтийн үе шатанд хязгаарлагдмал байгааг харуулна.

Төсвийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд нь:

- Хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэх засаглалын төсвийн саналыг баталгаажуулахаасаа өмнө хэлэлцүүлэг зохион байгуулдаггүй.
- Хууль тогтоох байгууллага нь жилийн явцын төсвийн хэрэгжилтийг судалдаггүй ба онлайнар тайлан нийтэлдэггүй.
- Бодит байдал дээр Засгийн газар батлагдсан төсвийн хуваарилалтыг байгууллага (яам, газар, агентлаг) хооронд өөрчлөхөөс өмнө хууль тогтоох байгууллагатай урьдчилж зөвлөдөггүй.

Аудитын дээд байгууллагаас төсөвт тавьж буй хяналт



Аудитын дээд байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт **хангалттай** түвшинд байна.

- Хуулийн дагуу уг байгууллага нь тохиромжтой гэж үзсэн хэлбэрээр аудит хийх эрх мэдэлтэй байдаг.
- Түүнчлэн аудитын дээд байгууллагын удирдлагыг хууль тогтоох байгууллагаас томилдог бөгөөд хууль тогтоох байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөх боломжгүй байдаг нь тус байгууллагын хараат бус байдлыг хангахад чухал ач холбогдолтой.
- Эцэст нь аудитын дээд байгууллагад өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах хангалттай нөхцөл, боломж бүрдүүлж өгдөг ч аудитын үйл явцыг өөр бие даасан агентлаг хянан шалгадаггүй.

Хараат бус санхүүгийн институтын хяналт

Монгол Улсад хараат бус санхүүгийн институт байдаггүй. Дэлхийн хэмжээнд өргөн тархаагүй ч хараат бус санхүүгийн институт нь нам бус, мэдээллийн чухал эх үүсвэр гэж хүлээн зөвшөөрөгддөг. Олон төрлийн хараат бус санхүүгийн институтууд байдаг. Жишээ дурдахад парламентын төсвийн алба ба санхүүгийн зөвлөл зэрэг болно.

Нэмэлт мэдээллийг Лиза фон Трапп, Иан Лиенерт ба Жоахим Вехнер нарын "Хараат бус санхүүгийн институтын зарчим, Кейс судалгаа" (*OECD Journal on Budgeting*, 2016 он 3 сар (онцлох дугаар),х.9-24)–аас үзнэ үү.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын судалгааны дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг survey.internationalbudget.org хаягаар орж авна уу.



Монгол Улс ил тод байдлыг хэрхэн сайжруулах боломжтой вэ?

Төсвийн ил тод байдлыг сайжруулахын тулд Монгол Улс дараах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Хагас жилийн тойм болон жилийн эцсийн тайланг онлайнар нийтлэх.
- Төсвийн хүрээний мэдэгдлийг цаг тухайд нь онлайнар нийтлэх.
- Иргэдэд зориулсан төсөв боловсруулах, онлайнар нийтлэх.



Монгол Улс иргэдийн оролцоог хэрхэн сайжруулах боломжтой вэ?

Төсвийн үйл явцад иргэдийн оролцоог сайжруулахын тулд дараах арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Төсвийн төлөвлөлт төдийгүй хэрэгжилтийг хянах үе шатанд олон нийт нь гүйцэтгэх засаглалын албан тушаалтнуудтай улсын төсвийн асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлдэг тогтолцоо нэвтрүүлэх. Энэхүү тогтолцоогоо иргэдийн оролцоотой төсөв, нийгмийн аудит зэрэг шинэлэг аргачлал дээр үндэслэн боловсруулж болно. Нэмэлт мэдээлэл, жишээг дараах хаягаас авна уу.
www.fiscaltransparency.net/mechanisms/
- Жилийн төсвийн төлөвлөлтийн талаар сонсгол зохион байгуулах. Сонсголын үеэр иргэд, иргэний нийгмийн байгууллагууд гэрчийн мэдүүлэг өгөх боломжтой байх.
- Аудитын шалгалтад иргэдийн оролцоо боломжийг хангасан албан ёсны тогтолцоо бий болгох.



Монгол Улс төсвийн хяналтыг хэрхэн сайжруулах боломжтой вэ?

Төсвийн хяналтыг сайжруулахын тулд дараах арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Гүйцэтгэх засаглал төсвийн саналыг боловсруулахаас өмнө хууль тогтоох байгууллага нь төсвийн бодлогын талаар хэлэлцүүлэг зохион байгуулан санал зөвлөмж гаргах.
- Хууль тогтоох байгууллагын төсвийн асуудал эрхэлсэн хороо нь төсвийн жилийн явцын тайланг хянаж, санал зөвлөмжөө онлайнаар нийтэлдэг байх.
- Аудитын үйл явцыг бие даасан агентлаг хянадаг байх.
- Төсвийн хяналтыг улам сайжруулахын тулд хараат бус санхүүгийн институт бий болгох талаар анхаарах.

АРГАЧЛАЛ

Төсвийн нээлттэй байдлын судалгаанд Олон улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага, Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага, Дэлхий нийтийн санхүүгийн ил тод байдлын санаачилга зэрэг олон талт хамтын ажиллагааны байгууллагуудаас боловсруулан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгуурыг ашигладаг.

Энэ нь бодит байдалд өрнөж буй үзэгдлийг ажиглан дүгнэдэг, баримтад тулгуурласан судалгааны хэрэгсэл юм. Судалгааг 2016 оны 8 дугаар сараас 2018 оны 1 дүгээр сар хүртэл нийт 18 сарын хугацаанд 115 улс орны 300 орчим шинжээчийг оролцуулан хийж гүйцэтгэсэн болно. 2017 оны Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь зөвхөн 2016 оны 12 дугаар сарын 31 хүртэлх үйл явдалд хамааралтай. Төсвийн мэдээллийг түгээх, нийтлэх арга хэлбэр өөрчлөгдөж эхэлсэнтэй уялдуулан мөн иргэдийн оролцоо болон төсвийн хяналттай холбоотой асуултуудыг сайжруулах зорилгоор судалгааг 2015 оныхоос тодорхой хэмжээгээр өөрчилсөн. Эдгээр өөрчлөлтийн талаарх мэдээллийг төсвийн нээлттэй байдлын судалгааны тайлангаас доорх холбоосоор орж үзнэ үү.

Судалгааны дүгнэлтийг ихэнх тохиолдолд эх сурвалж, саналаар баталгаажуулсан ба үүнд нийтэд ил тод болсон баримт бичгийн эшлэл, засгийн газрын албан ёсны мэдэгдэл, төрийн албан хаагч буюу бусад мэдээлэл бүхий этгээдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлд үндэслэсэн болно.



Тухайн орны Засгийн газарт хамаарахгүй, **хараат бус төсвийн шинжээчдийн** бөглөсөн асуулгыг ашигладаг.



Дараа нь засгийн газарт хамаарахгүй, хараат бус, **нэр нууцалсан** шинжээчид улс орон бүрийн судалгааны урьдчилсан дүнг хянадаг.



Түүнчлэн Олон улсын төсвийн түншлэл байгууллага судалгааны урьдчилсан дүнгийн талаар саналаа өгөхийг **засгийн газруудаас** хүсэж, судалгааны дүнг эцсийн байдлаар гаргахаас өмнө саналуудыг авч үздэг.



Үнэлгээний тэгш байдлыг хангахын тулд **судлаачид/хянагчид**, засгийн газар болон **олон улсын төсвийн түншлэлийн** шинжээчдийн санал, асуултуудад хариулдаг.

Олон улсын төсвийн түншлэл байгууллага нь Монгол Улсын Засгийн газраас Төсвийн нээлттэй байдлын судалгааны урьдчилсан дүнд санал авахаар хэд хэдэн удаа оролдлого гаргасан боловч санал авч чадаагүй болно.

Төсвийн нээлттэй байдлын судалгааны ажлыг гүйцэтгэсэн:
Нээлттэй Нийгэм Форум
Жамьян гүний гудамж – 5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14240,
Монгол Улс
Э-шуудан: osf@forum.mn

Нэмэлт мэдээлэл

openbudgetsurvey.org вэб хуудаснаас дараах нэмэлт мэдээлэл авна уу. Үүнд:

- Төсвийн нээлттэй байдлын судалгаа 2017: Дэлхийн тайлан
- Мэдээлэл
- Арга зүйн тайлан
- Судалгааны асуулгууд